



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИК
ТӨВРӨГ



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ (2018 оны 09 сард)




2018.10.10


www.dornogovi.nso.mn



БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД



965



468

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд



443 иргэн ажилд зуучлагдан оржээ

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2018 оны 09 сарын байдлаар 965 болсны 915 (94.8%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 50 (5.2%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт ажилгүй иргэдийн 468(48.5 %) нь эмэгтэйчүүд байна.


Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 590(37.9%) хүнээр буурч, өмнөх сараас 231(31.5%) хүнээр өссөн байна.

Хөдөлмөрийн хэлтэст 2018 оны эхний 09 сард 2201 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 443 иргэн ажилд зуучлагдан орж, 200 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна.

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД



Бүртгэлтэй ажил хайгч иргэд, боловсролын түвшнээр, 2018 оны 09 сард





ЭРҮҮЛ МЭНД



Дорноговь аймгийн хэмжээнд 2018 оны 09 сард 1034 эх амаржиж, 1037 хүүхэд шинээр мэндэлжээ. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 86(9.1%)-аар, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 83(8.7%)-аар, 298 хүн нас барсан нь 44(17.3%)-өөр тус тус өссөн байна.



Нялхсын эндэгдэл 13 байгаа нь өмнөх оны мөн үеэс 4-өөр өсчээ.



Он гарсаар эхийн эндэгдэл гараагүй




Халдварт өвчний 533 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 33(5.8%)-аар буурчээ.



Халдварт өвчний тохиолдол буурахад вирус гепатит 12.5 хувь, бусад төрлийн өвчин 58.4 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

ЭРҮҮЛ МЭНД

Нас баралт, өвчний шалтгаанаар, хувиар. 2018 оны 09 сард





НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

01

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газрын мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны эхний 09 сард 23799.1 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3324.8 (16.2%) сая төгрөгөөр өссөн байна.

02

Нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны эхний 09 сард өмнөх оны мөн үеэс 16.2 хувиар нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 2727.4 (22.3%) сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сан 455.6 (22.5%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 310.0 (22.3%) сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

03

Нийгмийн даатгалын сангийн зарлага 33303.6 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 4158.7 (14.3%) сая.төгрөгөөр өссөн байна.

04


Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 24203.9 (72.7%) сая.төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 4809.7 (14.4%) сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас 1873.6 (5.6%) сая.төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 1813.4 (5.4%) сая.төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 603.0 (1.8%) сая төгрөгийг зарцуулжээ.

05

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2018 оны эхний 09 сард нийгмийн халамжийн сангаас 22998 иргэнд 6069.9 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ

ГЭМТ ХЭРЭГ

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, үйлдэгдсэн цагаар



Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр оны эхний 9 сарын байдлаар 396 хэрэг бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 138(25.8%)--аар буурсан байна.

Өмнөх оны мөн үеэс нийт гэмт хэрэг буурахад өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 54(23.9%)-өөр, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 28 (21.7%)-аар, улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг 23(53.5%)-аар, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 17(68.0%)-аар, хүний амины гэмт хэрэг 14(73.7%)-өөр буурсан нь голлон нөлөөлөв.

Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 708.1 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3394.8(82.7) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлын 415.6(58.7%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.



МӨНГӨ, ЗЭЭЛ

Хадгаламжийн үлдэгдэл, сая.төг



2017 I-IX

75012.1

2018 I-IX

93933.1

Зээлийн өрийн үлдэгдэл, сая.төг



2017 I-IX

199555.5

2018 I-IX

252552.2

-Иргэдийн мөнгөн хадгаламж
93.9 тэрбум төгрөг болж

18.9 тэрбум ↑

- Нэг хадгаламж эзэмшигчдэд
1354.0 мянган төгрөг

224.1 мян.төг ↓

- Нэг хүнд дундажаар 1377.3
мянган төгрөг болж

251.0 мян.төг ↑

- Хадгаламж эзэмшигчийн тоо
69.4 мянган хүн болж

4.5 % ↑

-Зээлдэгчийн тоо 32.0 мянган
хүн болж

16.3 % ↑


- Зээлийн өрийн
252.6 тэрбум болж

26.6% ↑




МӨНГӨ, ЗЭЭЛ

ЗЭЭЛ, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2018.09-р сард



Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2018.09-р сард



ТӨСӨВ, САНХҮҮ



2018 оны эхний 09 сарын байдлаар орон нутгийн төсөвт 20061.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 101.8 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 20.3 хувиар өссөн байна. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 75.9 хувийг татварын, 24.1 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн
орлого, сая төг

16675.6 20061.5

2017 I-IX


2018 I-IX

Орон нутгийн төсвийн
зарлага, сая төг

40235.2 38996.5

2017 I-IX

2018 I-IX



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 09-р сард өмнөх сарын мөн үетэй адил харин өмнөх оны мөн үеэс 4.7 хувиар өссөн байна.



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 4.7 хувиар өсөхөд: хүнсний бараа, ундаа усны бүлэг 4.9 хувь, согтууруулах ундаа, тамхи 4.3 хувь, хувцас бөс бараа, гутал 2.5 хувь, орон сууц, ус, цахилааны, түлшний бүлэг 1.0 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 1.6 хувь, эм, тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 22.6 хувь, тээвэр 6.7 хувь, амралт чөлөөт цаг соёлын бараа 6.2 хувь, боловсролын үйлчилгээ 9.9 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 3.9 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлэг 2.8 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.




ХӨДӨӨ АЖ АХУЙ

Бойжиж буй төлийн тоо, 2015-2018 оны 9-р сарын байдлаар, толгой



	2015.I-IX	2016.I-IX	2017.I-IX	2018.I-IX
Бүгд	532414	469517	586705	604177
Ботго	6048	6005	6668	6552
Унага	19901	12817	21649	21757
Тугал	17496	12753	16615	17910
Хурга	250294	236632	286903	298453
Ишиг	238675	201310	254870	259505

Том малын зүй бус хорогдол, 2015-2018 оны 9-р сарын байдлаар, толгой





АЖ ҮЙЛДВЭР



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2018 оны эхний 09 сард 159947.6 сая төгрөг төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 49191.0(44.4%) төгрөгөөр өслөө.




Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2018 оны эхний 09 сард 231300.4 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 55970.2(31.9%) төгрөгөөр өслөө.




АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлт салбараар



Аж үйлдвэрийн нийт борлуулалт салбараар





АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт, дэд салбараар, оны үнээр, сая төгрөг

Салбар	2016 I-IX	2017 I-IX	2018 I-IX	2017 I-IX 2018 I-IX
	сая.төг			хувь
Дүн	11011.9	110757.5	159947.6	144.4
Уул үүрхай олборлох аж үйлдвэр	3773.2	57394.7	79853.2	139.1
Нүүрс олборлолт	3773.2	57394.7	79853.2	139.1
Бусад ашигт малтмал олборлолт				
Боловсруулах аж үйлдвэр	927.7	48798.8	75582.9	154.9
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	557.4	17052.2	874.2	5.1
мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	33.4	16458.5	283.3	1.7
сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	77.9	125.8	119.0	94.6
хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	446.1	467.9	471.9	100.9
Хувцас үйлдвэрлэл	42.6	23.6	36.2	153.4
Гутал үйлдвэрлэл	6.4	9.4	5.9	62.8
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	26.6	32.2	55.2	171.4
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	0.2	0.3	0.2	66.7
Боловсруулах үйлдвэрийн бусад	294.5	31681.1	74611.4	235.5
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	6311.0	4564.0	4511.5	98.8
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	5042.4	3056.9	1577.8	51.6
Ус ариутгал, усан хангамж	1268.6	1507.1	2933.7	194.7

БАРИЛГА



2018 оны эхний 9 сарын байдлаар нийт 348185.5 сая төгрөгийн шинэ барилга, өргөтгөл, шинэчлэлт, их засварын ажил хийсэн нь өмнөх онтой харьцуулахад 4.0 дахин нэмэгдсэн байна.





ТЭЭВЭР

01

Оны эхний 9-р сарын байдлаар ачаа эргэлт 41067.2 мян.тн.км байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 7029.2 (20.7%) нэмэгдсэн байна

02

Тээсэн ачаа 136.2 мян.тн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 13.4 (10.9%) буурсан байна

03

Оны эхний 9-р сарын байдлаар зорчигч эргэлт 10301.0 мян.хүн.км байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 3219.0 (45.5%) нэмэгдсэн байна

04

2018 оны 09-р сарын байдлаар зорчигчын тоо 66.1 мян.хүн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 23.5 (55.2%) нэмэгдсэн байна

05

Тээврийн салбарын орлого 7805.2 сая төгрөг байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 25.6 (0.3%)-аар нэмэгдсэн байна



СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?

Статистикийн лавлах

1900-1212

Статистикийн мэдээллийн
нэгдсэн сан

www.1212.mn

Дорноговь аймгын
Нутгийн
удирдлагын
ордоны 106 тоот



Статистик мэдээлэл



@statistic_mn

www.nso.mn сайтын
Хэрэглэгчийн бүртгэлд
бүртгүүлж мэдээлэл авах



Улаанбаатар / 2015